



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

「 Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2013 оны “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, Самбалхүндэвийн оршуулгын газрын 10 га талбайд бурхан болоочдыг дурсан хүндэтгэх иж бүрэн тохижилт, барилга, байгууламж бүхий дурсгалын цэцэрлэгт хүрээлэн байгуулах төслийг дэмжиж, төсөл хэрэгжүүлэх талбайн солбицлын цэгийг хавсралт ёсоор баталсугай.

2.Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн байгуулах төсөл арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн төр, хувийн хэвшлийн оролцоог хангаж зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 15 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 1 дэх хэсэгт заасан Самбалхүндэвийн оршуулгын газрын талбайн хэмжээг 69,3 га болгон өөрчилсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН